

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН  
САХИЛГЫН ДҮРЭМ  
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэгдүгээр зүйл. Ерөнхий зүйл

1.1. Цагдаагийн алба хаагчийн сахилгын дурмийн зорилго нь цагдаагийн албаны хэвийн үйл ажиллагаа, захирах захирагдах ёс, хүний эрхийг хангах, алба хаагчийн сажиж, **сахилгын хэм хэмжээг тогтоох**, хариуцлагыг журамлан зохицуулах замаар тэдний эрх ашиг, цагдаагийн байгууллага, алба хаагчийн нэр хүндийг хамгаалахад оршино.

1.2. Цагдаагийн алба хаагч нь Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон байгууллагын дотоод журам, цагдаагийн алба хаагчийн тангаргаар хүлээсэн үүргээ чанд сахин биелүүлэхийг цагдаагийн алба хаагчийн сахилга гэнэ.

1.3. Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм /цаашид “Сахилгын дүрэм” гэнэ/ нь цагдаагийн алба хаагчдад тавигдах нийтлэг шаардлага, зарчим, сахилгын зөрчлийн төрөл, хэлбэрийг тодорхойлно.

1.4. Цагдаагийн алба хаагчийн сахилга нь энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг сажиж биелүүлснээр илэрхийлэгдэнэ.

Алба хаагч нь Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон байгууллагын дотоод журам, цагдаагийн алба хаагчийн тангаргатсаа үнэнч байж, үүрэг болон хууль тогтоомжийг чанд сахин биелүүлнэ.

1.4. Цагдаагийн алба хаагч өргөсөн тангаргатсаа үнэнч байж, түүнийг ёсчлон биелүүлнэ.

1.5. Энэ дүрэмд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.5.1. “цагдаагийн алба хаагчийн сахилга” гэж Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон байгууллагын дотоод журам, цагдаагийн алба хаагчийн тангаргаар хүлээсэн үүргээ чанд сахин биелүүлэхийг;

1.5.2. “сахилгын зөрчил” гэж холбогдох хууль тогтоомж болон энэ дүрмээр тогтоосон сахилгын хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;

1.6. Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм /цаашид “Сахилгын дүрэм” гэнэ/ нь цагдаагийн алба хаагчдад тавигдах нийтлэг шаардлага, зарчим, сахилгын зөрчлийн төрөл, хэлбэрийг тодорхойлж, сахилгын зөвлөгөөн хийх, шийтгэл оногдуулахтай холбогдсон харилцааг зөхицуулна.

Цагдаагийн алба хаагчийн сахилга нь энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг сажиж биелүүлснээр тодорхойлогоно.

1.7. Цагдаагийн алба хаагч бүр өргөсөн тангаргатсаа үнэнч байж, түүнийг ёсчлон биелүүлж, сахилгын дурмийг сахин биелүүлэх үүрэгтэй.

1.8. Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтнууд нь тушаалтан сахилга, дэг журмыг бэхжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй, алба хаагчдад буруу үлгэр дуурailал үзүүлэх үзүүлж, зөхисгүй харьцах, сахилга, дэг журмыг бэхжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн бусдыг аливаа хэлбэрээр хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах, түүнчлэн дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэх, хууль бус тушаал, шийдвэр биелүүлэхийг шаардах нь сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно.

1.9. Алба хаагч нь үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйл, Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг тус тус баримтална.

## **Хоёрдугаар зүйл. Сахин баримтлах хэм хэмжээ**

2.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний Цагдаагийн үйл ажиллагаанд холбогдох заалт, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 онд баталсан Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль, Интерполоос баталсан дүрэм, журам, Монгол Улсын хууль тогтоомж, Цагдаагийн тангараг, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Цагдаагийн төв байгууллагаас тогтоосон цагдаагийн байгууллагын хөдөлмөрийн дотоод буюу үйл ажиллагааны журам болон энэ дүрмийг алба хаагч бүр дагаж мөрднө.

2.2. Алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж удирдлагаар хангах эрх бүхий албан тушаалтны хуульд нийцсэн зөвлөмж, шийдвэрийг дагаж мөрднө.

2.1.1. Алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж удирдлагаар хангах эрх бүхий албан тушаалтны хуульд нийцсэн зөвлөмж, шийдвэрийг дагаж мөрдөх;

2.1.2. Албаны болон алба хаагчийн нэр хүндийг хамгаалж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу үйл ажиллагаа явуулах;

2.1.3. Улс төрөөс ангид байж, санаа бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, уг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрхээ здлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандаж, алба хаагчийн ёс зүйд харш үйлдэл, эс үйлдлийг гаргахгүй байх;

2.1.4. Албан үүргээ биелүүлэхдээ байгууллагын үнэт зүйл, эрх ашгийг ямагт эрхэмлэн дээдэлж, амин хувийн эрх ашигт автахгүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

2.1.5. Албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, танил тал харах, аливаа этгээдийн өмнө хууль бус үүрэг хүлээх, албан үүргээ хэрэгжүүлсний төлөө бэлэг, дурсгал, шан харамж авахгүй байх;

2.1.6. Үндсэн ажил, албан үүргээсээ гадуур хуулиар хүлээн зөвшөөрснөөс бусад ажил, албан тушаал хавсран гүйцэтгэхгүй байх;

2.1.7. Албан үүрэгтэй холбоотой нь илэрхий болсон буюу эсвэл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн болон албаны, хувь хүний нууцыг задруулахгүй байх;

2.1.8. Удирдлагын зөвшөөрөлгүйгээр албан ажлын талаар нийтэд болон бусдад мэдээлэл өгөх, мэдээлэл дамжуулахгүй байх;

2.1.9. Чиг үүргийн дагуу аливаа асуудлыг шалгахдаа танил тал харах, бусдыг ялгavarлах, хунд суртал гаргах, чирэгдүүлэх зэргээр хүний эрх, эрх чөлөөг үл хүндэтгэх байдал гаргахгүй байх;

2.1.10. Байгууллагын өмч хөрөнгө, техник болон тусгай хэрэгсэл, албан хэрэгцээний мэдээ материалы, мэдээллийн санг албаны бус зориулалтаар ашиглахгүй байх;

2.1.11. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын цагаар, албаны байранд, мөн үүрэг гүйцэтгэж томилолтоор яваа үедээ согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бусад эм, бэлдмэл болон бусад бодис хэрэглэхгүй байх;

2.1.12. Байгууллагын даргын зөвшөөрөлгүйгээр албаны болон хувийн ажлаар гадаадад зорчих, түүнчлэн дотоод, гадаадын байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүний зардлаар аялах, жуулчлах, амрахгүй байх;

2.1.13. Аливаа уулзалт, дайллага, хүлээн авалтад оролцохдоо албаны нэр хүндийг дээдэлж, хөндлөнгийн ямар нэг нөлөөнд автахгүй байх;

2.1.14.Албан үүргээ гүйцэтгэхэд иргэн, албан тушаалтнаас нөлөөлсөн дарамт шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар дээд шатны удирдлагад мэдэгдэх;

2.1.15.Алба хаагч ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үед тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх;

2.1.16.Албаны үнэмлэх, тэмдгийг хууль бусаар хэрэглэх, албаны нэрийг хувийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх.

Гуравдугаар зүйл.Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл

3.1.Цагдаагийн албан хаагчид дараах үндэслэлээр сахилгын шийтгэл ногдуулна.

3.1.1.Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, ёс зүйн дүрмийг зөрчсөн;

3.1.2.Удирдах албан тушаалтнаас хуулийг дагаж мөрдөх талаар гаргасан тушаал, үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй;

3.1.3.Байгууллагын дотоод дүрэм, журам зөрчсөн;

3.1.4.Хуульд заасан албаны чиг үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй;

3.1.5.Цагдаагийн албан хаагчийн ажлын хариуцлага, мэргэжлийн ур чадвараас шалтгаалсан алдаанаас хууль тогтоомж зөрчигдсөн нь тогтоогдсон.

3.2.Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл, зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд заавал шалгаж тогтоосон байна.

Дөрөвдүгээр зүйл.Сахилгын дүрэм зөрчсөн албан хаагчид хүлээлгэх хариуцлага

4.1.Энэ дүрэмд заасан сахилгын хэм хэмжээг зөрчсөн нь тухайн алба хаагчид Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд хариуцлага ногдуулах үндэслэл болно.

4.2.Алба хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэхтэй холбогдсон харилцааг тусгай журмаар зохицуулна.

---оо---

### **Гуравдугаар зүйл. Сахилгын зөрчия**

- 3.1. Энэ дүрмээр хориглож, шийтгэл ногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүүг сахилгын зөрчил гэж үзэн.
- 3.2. Алба хаагчийн гаргасан үйлдэл, эс үйлдэхүүг сахилгын зөрчил гэж үзэн албан тушаалтан энэ тухай тэмдэглэл үйлдэж зөрчил гаргасан байж болох алба хаагчид заавал мэдэгдэж, хариу тайлбарыг авна. Албаны шалгалт явуулж сахилгын зөрчил үйлдэгдсэн эсэхийг тогтоон.
- 3.3. Зөрчил гаргасан нь тогтоогдсон бол зөрчлийн шалтгаан нөхцөлийг заавал судалж тогтоон байгууллагын удирдлагад танилцуулна.

### **Дөрөвдүгээр зүйл. Сахилгын зөрчлийн талаарх өргөдөл, гомдол**

- 4.1. Алба хаагч сахилгын зөрчил гаргасан тухай өргөдөл, гомдлыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн бөл албаны шалгалт явуулна.
- 4.2. Албаны шалгалтыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд явуулна. Энэ хугацааны дотор Цагдаагийн байгууллагын дарга албаны шалгалт явуулах хугацааг тогтоож болно.
- 4.3. Өргөдөл, гомдлын мөрөөр ямар арга хэмжээ авч, хэрхэн шийдвэрлэсэн талаар өргөдөл, гомдол гаргагчид хариу мэдэгдэнэ.
- 4.4. Цагдаагийн төв байгууллагын Аюулгүй байдал хариусан нэгж нь сахилгын зөрчлийн талаарх өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар мэдээллийн сан үүсгэж, хотөлнө.
- 4.5. Гаргасан өргөдөл, гомдол нь үндэслэлгүй бөгөөд алба хаагчийг илт гүтгэсэн шинжтэй болох нь тогтоогдвол хуулийн дагуу харьялах эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

### **Тавдугаар зүйл. Сахилгын зөрчлийг шалгаж тогтоох**

- 5.1. Цагдаагийн төв байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг Аюулгүй байдал хариусан нэгж, бусад цагдаагийн байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухайн байгууллагын даргын төмилсөн албан тушаалтан хүлээн авч, албаны шалгалт явуулна.
- 5.2. Албаны шалгалт явуулж байгаа албан тушаалтан нь шууд нотлох баримт, үндэслэл бүхий мэдээ, мэдээлэл, бусад баримтад тулгуурлан сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх, гаргасан зөрчилд тохирсон шийтгэл оногдуулах санал гаргах зарчмыг баримтална.
- 5.3. Албаны шалгалт явуулсан алба хаагч нь холбогдох хууль тогтоомжийг үндэслэл бөлгөн дараах саналыг гаргана:
- 5.3.1. сахилгын зөрчил биш бол гомдол гаргагч иргэнд хариу мэдэгдэх;
- 5.3.2. сахилгын шийтгэл оногдуулах санал гаргах;
- 5.3.3. гэмт хэргийн шинжтэй гомдол. мэдээллийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх.
- 5.4. Алба хаагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхэд тухайн алба хаагчийн сахилгын зөрчил гаргаагүй нь шагнаж урамшуулах үндэслэл болно.

### **Зургаадугаар зүйл. Сахилгын шийтгэлийг хүндруулэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал**

- 6.1. Сахилгын шийтгэл оногдуулахдаа зөрчлийн шинж байдал, гэм буруугийн хэлбэр, хор уршиг, үр дагавар, анх буюу давтан үйлдсэн эсэх, шалтгаан нөхцөл, зөрчил гаргагчийн хувийн байдлыг харгалзан үзнэ.

6.2. Сахилгын зөрчлийн улмаас бусдад хөхирөл учирсан, албаны үйл ажиллагаа удааширч саатсан, албаны нэр хүндэд нүцтөй хөхирөл учирсан бол зөрчлийн хөр уршиг, гэм буруугийн шинж байдлыг харгалзан сахилгын шийтгэлийг хүндруулж оногдуулна.

6.3. Сахилгын шийтгэлгүйд төөцөх хугацаа дуусагүй байжад сахилга, ёс зүйн зөрчил давтан гаргасан нь хүндруулэх нөхцөл байдал болно.

6.4. Сахилгын зөрчил гаргасан алба хаагчийн буруугийн хэлбэр, буруугаа ухамсарласан байдал, ажлын зөрэг үр дүн, ёс зүйн төлөвшил, байгуулсан гавьяя, шинээр санаачилсан ажил зэргийг үнэлж хөнгоруулэх нөхцөл байдалд харгалзан үзэж болно.

6.5. Цагдаагийн албаны тухай хуулийн 81.9 дэх хэсэгт заасан үндэслэл тогтоогдвол алба хаагчид оногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас өмнө сахилгын шийтгэлгүйд төөцөж болно.

6.6. Энэ дүрэмд заасныг зөрчиж, сахилгын зөрчлийн хөр уршиг, шинж байдалд илт үл нийцэн, үндэслэлгүйгээр сахилгын шийтгэлийг хүндруулж, эсхүл хөнгоруулж оногдуулсан албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

### **Дөлдугаар зүйл. Сахилгын зөрчилд нөгдүүлах шийтгэл, хугацаа**

7.1. Алба хаагч энэ дүрэмд заасан зөрчил гаргасан нь тогтоогдвол Цагдаагийн албаны тухай хуулийн 81.4 дэх хэсэгт заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг оногдуулна.

7.2. Алба хаагч нь Авлигын зөрэг хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хуулийг зорчсон бол тухайн хуульд заасан сахилгын шийтгэлийг оногдуулна.

7.3. Сахилгын шийтгэл оногдуулахдаа Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2, 48.4-48.6, Цагдаагийн албаны тухай хуулийн 81.8 дахь хэсэгт заасан журмыг баримтэлна.

*/Энэ хэсээт ЦЕГ ын дарын 2020 оны А/107 дугаар тушаалаар өөрчлөлт орсон./*

7.4. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сарын хугацааг төөлөхдөө тухайн алба хаагчийн сахилгын зөрчил гаргасныг шийдвэр гаргах эрх бүхий цагдаагийн байгууллагын дарга олж мэдсэн буюу шалгалтын дүгнэлттэй танилцсан үеэс эхлэн төөлнө.

7.5. Алба хаагч сахилгын шийтгэл оногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдолоо тухайн шийдвэрийг мэдсэн одрөөс хойш 1 сарын дотор дээд шатны байгууллага, эсхүл шүүхэд гаргаж болно.

### **Наймдугаар зүйл. Сахилгын шийтгэл оногдуулах эрх бүхий албан тушаалтан**

8.1. Алба хаагчийн гаргасан сахилгын зөрчилд явуулсан албаны шалгалтын дунг цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэн. Шаардлагатай гэж үзвэл эрх бүхий албан тушаалтан нь албаны шалгалтын дунг үндэслэн шууд тушаал гаргаж сахилгын шийтгэл оногдуулж болно.

8.2. Цагдаагийн төв байгууллагын дарга нь Цагдаагийн албаны тухай хуулийн 81.4 дэх хэсэгт заасан сахилгын шийтгэлийг оногдуулна.

8.3. Цагдаагийн төв байгууллагын харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь цагдаагийн дунд, ахлах, дээд цолтой буюу офицер бүрэлдэхүүнээс гаргасан сахилгын зөрчилд Цагдаагийн албаны тухай хуулийн 81.4.1, 81.4.2 дахь хэсэгт заасан сахилгын шийтгэлийг оногдуулна.

8.4. Цагдаагийн төв байгууллагын харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан

цагдаагийн байгууллагын дарга нь ахлагч цөлтой буюу ахлагч бүрэлдэхүүнээс гаргасан сахилгын зөрчилд Цагдаагийн албаны тухай хуулийн 81.4.1, 81.4.2, 81.4.4, 81.4.5 дахь хэсэгт заасан сахилгын шийтгэлийг оногдуулна.

8.5. Зөвлөлийн хуралдаанаар хөлөлцсөн тохиолдөлд түүнээс гаргасан шийдвэрийн дагуу сахилгын шийтгэл оногдуулах эрх бүхий цагдаагийн байгууллагын дарга сахилгын шийтгэл оногдуулах тухай тушаал гаргана.

#### **Есдүгээр зүйл. Судалгаа, тайллан**

9.1. Алба хаагчдаас сахилгын зөрчил гаргуулахгүй байх зорилгоор бүртгэгдэж шийдвэрлэгдсэн зөрчилд судалгаа, дун шинжилгээ хийж, мэдээллийг харьяа нэгж, байгууллагуудад хүргүүлнэ.

9.2. Цагдаагийн төв байгууллагын Аюулгүй байдал хариуцсан нэгж нь сахилга, ёс зүйн зөрчлийн талаар хийсэн судалгаа, дун шинжилгээг нэгтгэн бөлөвсруулж эрх бүхий байгууллага, албан тушаалтан, олон нийтэд тайлагнана.

9.3. Судалгаа шинжилгээний дунг үндэслэн эрх бүхий албан тушаалтан, байгууллагатай хамтран, алба хаагчдын гаргасан сахилгын зөрчлийг бууруулах ажлыг зөхион байгуулна.

9.4. Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага гэмт хэрэг, зөрчилд хөлбөгдсөн, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчийн хөлбөгдөх мэдээллийг цагдаагийн байгууллагын дотоод хяналт, шалгалтын /ICS/ программ хангамжийн мэдээллийн санд тухай бүр оруулж, баяжилт хийнэ.

*/Энэ хэсгийг ЦГГ-ын дарзын 2020 оны А/107 дугаар тушаалаар нэмсэн./*

9.5. Цагдаагийн байгууллагын дотоод хяналт, шалгалтын /ICS/ мэдээллийн сангийн программ хангамж, хэвийн ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг цагдаагийн төв байгууллагын мэдээллийн технологи хариуцсан нэгж, сангийн ашиглалтыг Аюулгүй байдал хариуцсан нэгж тус тус хариуцна.

*/Энэ хэсгийг ЦГГ-ын дарзын 2020 оны А/107 дугаар тушаалаар нэмсэн./*

#### **Аравдугаар зүйл. Баримт улдээх**

10.1. Сахилгын шийтгэл хүлээсэн цагдаагийн алба хаагчийн хувийн хэрэгт тухайн шийтгэл оногдуулсан талаарх мэдээллийг оруулана.

10.2. Сахилгын зөрчилтэй хөлбоостой албаны шалгалтын материалыг хөлбөгдөх хууль тогтоомжид заасан хугацаанд хадгална.

#### **Арван нэгдүгээр зүйл. Сахилгын зөвлөгөөн хийж, үр дунг төөцөх**

11.1. Цагдаагийн байгууллага, нэгж нь улирал бүр сахилгын зөвлөгөөн хийж, энэ талаар танилцуулгыг дараа улирлын эхний сарын 10-ны дотор цагдаагийн төв байгууллагын Аюулгүй байдал хариуцсан нэгжид ирүүлнэ.

*/Энэ хэсгийг ЦГГ-ын дарзын 2020 оны А/107 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан./*

11.2. Сахилгын зөвлөгөөн нь тайлант хугацааны сахилгын байдлыг бүрэлдэхүүнд мэдээлэх, гарсан зөрчлийг шинжлэн хөлөлцэх, сахилга, хариуцлагын чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, түүний үр дунд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зэрээр алба хаагчийн төлөвшийлд нөлөөлөх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, асуудлыг хамтын оролцоотойгөөр шийдвэрлэх зорилготой.

Сахилгын зөвлөгөөнийг зөрилгөө хангах аль ч арга, хэлбэрээр зөхион байгуулж болно.

11.3. Цагдаагийн байгууллага, нэгж нь гарсан зөрчлийн үндсэн шалтгаан, нөхцөлийг бүртгэж, арилгах арга хэмжээ авна.

Зөрчлийн үндсэн шалтгаан, нөхцөлийг арилгахад төв болон бусад байгууллагын оролцоо, дэмжлэг шаардлагатай бөл ямар шалтгаан, нөхцөл байгааг аль байгууллагын, ямар оролцоотойгөөр хэрхэн шийдвэрлэх талаар санаалаа мэдээлэлд хавсаргана.

11.4. Сахилгын зөвлөгөөний мэдээлэлд сахилга, ёс зүйг төлөвшүүлэх, зөрчлийг бууруулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зөгсөөх чиглэлээр хийсэн шинэлэг, үр дүнтэй нь туршлагаар батлагдсан ажил, арга барилын талаар мэдээлнэ.

Энэ мэдээллийг Аюулгүй байдал хариуцсан нэгжээс судалж, бусад байгууллага, нэгжид түгээх, нэвтрүүлэх арга хэмжээг авах ба энэ тохиолдод мэдээлсэн байгууллага, нэгжийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг баримтлан урамшуулж болно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### ТОДОРХОЙ ТӨРЛИЙН САХИЛГЫН ЗӨРЧИЛ, ТҮҮНД ОНОГДУУЛАХ САХИЛГЫН ШИЙТГЭЛ

#### Арван хоёрдугаар зүйл. Алба хаагч хуулиар хүлээсэн үүргээ үл биелүүлэх

12.1. Албан үүргээ биелүүлэх явцдаа хууль тогтоомжийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөө, албаны нэр төрийг хүндэтгэн, оорийг хэн болохыг танилцуулаагүй, хүнлэг энэрэнгүй харьцах үүргээ биелүүлээгүй бөл училал хүсэхийг даалгаж, сануулах шийтгэл оногдуулна.

12.2. Гүйцэтгэх ажлын тухай хууль, тогтоомж зөрчсон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй, хуульд өөрөөр заагаагүй бөл сануулах, уг үйлдлийн улмаас хөр уршиг учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.3. Албан үүргээ гүйцэтгэхэд бусад хүн, албан тушаалнаас нөлөөлсөн дарамт шахалт, зөхимжгүй нөлөөллийн талаар дээд шатны удирдлагадаа мэдэгдээгүй үйлдэлд сануулах шийтгэл оногдуулна.

Тайлбар: Бусдын эрхшээл дарамт нь алба хаагчийг бие махбөд, сэтгэл зүйн хувьд гарцаагүй байдалд оруулсан бөлох нь тогтоогдвол шийтгэл нөгдүүлахгүй байж болно. Дарамт шахалтад орсон алба хаагчид удирдах албан тушаалтан, хамт олон нь сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж, шаардлагатай бөл ажлын цагаар амрах боломжоор хангана.

12.4. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгээгүй бөл зөрчлийн шинж байдлаас шалтгаалж сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.5. Гэрч, хөхирогчийг хамгаалах тухай хуульд зааснаар цагдаагийн байгууллагад даалгасан үүргийг биелүүлээгүй бөл сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.6. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам зөрчсон бөл сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

12.7. Эрх бүхий албан тушаалтын шийдвэрээр жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг гүйцэтгэх талаар тогтоосон журам зөрчсон бөл зөрчлийн байдлаас шалтгаалж сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн

~~хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.~~

~~12.8. Алба хаагчдыг олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах ажлыг зохион байгуулах үүргээ биелүүлээгүй, хуулиар тогтоосон журам зөрчсөн бөл сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.~~

~~12.9. Иргэн, хуулийн этгээд галт зэвсэг өмчлөх, ашиглах, галт зэвсэг, сум үйлдвэрлэх, зажиалах, худалдах, тээвэрлэх, эзэмших журмын биелэлтэд хяналт тавих үүргээ биелүүлээгүй бөл сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цөл бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орж эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.~~

~~12.10. Гэрээт харуулын бөлөн хувийн хамгаалалтын үйл ажиллагаа явуулах журмын биелэлтэд хяналт тавих үүргээ биелүүлээгүй бөл сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.~~

~~12.11. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээн авч бүртгэх, хойшлуулшгүй арга хэмжээ авах, таслан зогсоох, учирч бөлөх хор хөхирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх, гэмт хэргийг илрүүлэх үүргээ биелүүлээгүй бөл сануулах, уг үйлдлийн улмаас хор уршиг учирсан, албаны нэр хүнд, иргэний эрх зөрчигдсөн бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цөл бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орж эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.~~

~~12.12. Хуулиар харьяалуулсан гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цөл бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орж эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.~~

~~12.13. Хуулиар харьяалуулсан хэрэг зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагааны явцад мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, заавар, зөвлөмжийг өгөх, биелэлтийг тооцож үүргээ зөхиж ёсөөр биелүүлээгүй албан тушаалтанд сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах шийтгэл оногдуулна.~~

~~12.14. Алба хаагч ажил тасалсан, шууд удирдах албан тушаалтанд мэдэгдэлгүйгээр дур мэдэн ажлын байраа оржин явсан бол сануулах, удаа дараа, эсхүл б хоногөөс дээш тасалсан, бусдад хөхирол учирсан, албаны үйл ажиллагаа удааширч saatсан, албаны нэр хүндэд ноцтой хөхирол учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цөл бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орж эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.~~

~~12.15. Цагдаагийн төв байгууллагаас тогтоосон үйл ажиллагааны журмыг зөрчсөн бол сануулах, уг үйлдлийн улмаас бусдад хөхирол учирсан, албаны үйл ажиллагаа удааширч saatсан, албаны нэр хүндэд ноцтой хөхирол учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цөл бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орж эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.~~

~~12.16. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан оргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмыг зөрчсөн бол сануулах, уг үйлдлийн улмаас бусдад хөхирол учирсан, албаны үйл ажиллагаа удааширч saatсан, албаны нэр хүндэд ноцтой хөхирол учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орж~~

~~эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.~~

~~12.17. Цагдаагийн байгууллагын тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг зориулалтын бусаар ашигласан бөл сануулах, уг үйлдлийн улмаас хөр уршиг учирсан бөл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цөл бууруулах, эсхүл цагдаагийн албанад нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.~~

~~12.18. Албан үүрэгтэйгээ хөлбөгдөлгүй эсуудлаар нам, төрийн бус болон шашны байгууллагын үйл ажиллагаанд алба хаагчийн хувьд оролцсон бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах шийтгэл оногдуулна.~~

~~12.19. Удирдлагыг зөриуд буруу мэдээллээр хангасан бөл сануулах, албаны нэр хүндэд ноцтой хөхирол учирсан бөл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн албанад нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.~~

#### **Арван гуравдугаар зүйл. Цагдаагийн албаны тухай хууль зөрчих**

~~13.1. Гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн отгээдийн нэгдсэн тоо бүртэл хотлох, лавлагага гаргах журам зөрчсон бөл сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.~~

~~13.2. Олон улсын цагдаагийн байгууллага (интерпол)ын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, гадаад орны цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрээс хүлээн авсан мэдээ, мэдээллээр цагдаагийн нийт байгууллагыг хангах үүргээ биелүүлээгүй бөл сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цөл бууруулах, эсхүл цагдаагийн албанад нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл ногдуулна.~~

~~13.3. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь үйл ажиллагааныхаа тайланг аймаг, нийслэлийн иргэд, оршин суугчдад, түүнчлэн төдорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагч нь үйл ажиллагааныхаа тайланг тухайн нутаг дэвсгэрийн иргэдэд тавиагүй бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.~~

~~13.4. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын удирдлага нь Цагдаагийн төв байгууллага болон харьяалах Иргэний зөвлөлд ажлаа тайлагнах үүргээ биелүүлээгүй бөл сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.~~

~~13.5. Удирдах албан тушаалтны хууль ёсны шийдвэр, үүрэг даалгавар, тушаалыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бөл шалтгааныг тогтоож, сануулах шийтгэл оногдуулна. Хэрвээ энэ зөрчлийг давтан гаргасан, эсхүл зөрчлийн улмаас байгууллагын үйл ажиллагаа тасалдаж хөр уршиг учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цөл бууруулах шийтгэл оногдуулна.~~

~~13.6. Нутгийн захирагааны болон төрийн бус байгууллагаас зохион явуулж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах үүрэгтэй албан тушаалтан энэ үүргээ биелүүлээгүй бөл сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.~~

~~13.7. Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал болон бусад объектыг хамгаалах, зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх үед үүргээ хангалтгүй биелүүлсэн бол сануулах, хөр уршиг учирсан бол эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл~~

албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цөл бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

13.8. Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн өсөл, гол түймэр, хүн малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэмийг сахиулах үүргээ биелүүлээгүй бөл сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.

13.9. Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах үүргээ хангалтгүй биелүүлсэн бол сануулах, биелүүлээгүй бөл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн цөл бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

13.10. Эрх бүхий байгууллага, албан тушаалтын даалгаснаар сураггүй алга бөлсөн хүн, эд зүйлсийг эрэн сурвалжлаагүй бөл сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.

13.11. Алба хаагчдын өдөр тутмын ажилд хяналт тавьж, хууль тогтоомж, цагдаагийн алба хаагчийн сахияла, ёс зүй, хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, таслан зөгөөх арга хэмжээ авах үүрэгтэй албан тушаалтан энэ үүргээ биелүүлээгүй бөл сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл албан тушаал буурууллах шийтгэл оногдуулна.

13.12. Алба хаагч үүрэг гүйцэтгэх үед хэрэглүүлэхээр тавьж олгосон гав, бороохой, цахилгаан гүйдлээр цөхигч, нулимын асгаруулагч, амьсгал боогдуулагч, хөлбөөны хэрэгсэл, агсамж ашиглах үндэслэл, журмыг зөрчсөн бол сануулах, уг үйлдлийг давтан гаргасан, хөр уршиг учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл цагдаагийн цөл бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

13.13. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам зөрчсөн, мэдээллийн аюулгүй байдлыг алдагдуулсан, албаны мэдээллийг задруулсан бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл цагдаагийн цөл бууруулах, эсхүл албан тушаал бууруулах шийтгэл оногдуулна.

13.14. Байгууллагын үйл ажиллагааг шуурхай, үр дунтэй явуулах шаардлагыг хангах төсвийн төслийг үндэслэлтэй боловсруулах, санал гаргах ажлыг зохих журмын дагуу гүйцэтгээгүй бөл сануулах, уг зөрчлийг давтан гаргасан, байгууллагад хөр уршиг учруулсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл цагдаагийн цөл бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

13.15. Цагдаагийн цөл, түүнийг таних тэмдгийг хууль бусаар хэрэглэсэн, албаны нэрийг хувийн ашиг сөнирхлээр ашигласан бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэл оногдуулна.

13.16. Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь хөлбөгдуулан алба хаагчийг хүчирхийлэх, заналхийлэх, дөрөмжлох, гутгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас алба хаагч, түүний гэр булийн гишүүнийг цагдаагийн байгууллагаар хамгаалуулах эрхийг нь хангаагүй бөл сануулах, хөр уршиг учирсан бол албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл цагдаагийн цөл бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.

13.17. Дээд шатны байгууллага, албан тушаалтын хуульд нийцсэн үүрэг даалгавар, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах талаар ажлын байрны төдөрхийлөлтөд заасан үүргээ

~~хангалтгүй биелүүлсэн бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, биелүүлээгүй бол цагдаагийн цол бууруулах, эсхүл албан тушаал бууруулах шийтгэл оногдуулна.~~

~~13.18. Алба хаагчаар хуульд зааснаас eer ажил, уурэг гүйцэтгүүлсэн бол сануулах, эсхүл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл цагдаагийн цол бууруулах, эсхүл албан тушаал бууруулах, эсхүл цагдаагийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл оногдуулна.~~

---оОо---